



# МУИС-ИЙН БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

## “БИЗНЕСИЙН ГАРАА” ЭНТРЕПРЕНЁРУУДАД

### ЗОРИУЛСАН БОГИНО ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР



#### СУРГАЛТЫН ХУГАЦАА БА ТӨЛБӨР

Сургалт нь нийт 10 хоногийн хугацаанд үргэлжилнэ. Үндсэн 7 модулийг судалсаны дараа 2 хоногийн хугацаанд бизнес төлөвлөгөөгөө боловсруулж, сүүлийн өдөр бизнес төлөвлөгөөний уралдаанд оролцож, ялагчийг шалгаруулж, төгсөлтийн ёслол явагдана. Сургалтын төлбөр: 275000 төг

#### ОЛГОХ БАРИМТ БИЧИГ

МУИС-ийн Бизнесийн сургуулийн энтрепренёршипын богино хугацааны сургалтанд хамрагдсаныг гэрчлэх сертификат олгоно.

#### ХОЛБОО БАРИХ

Г. Нарангэрэл  
Утас: 99227130  
Цахим шуудан:  
naagii0116@yahoo.com  
Цахим хуудас: bs.num.edu.mn

Бизнес Консалтинг Төв

#### СУРГАЛТЫН ТОВЧ ТОЙМ

Хурдацтай өөрчлөгддөг, урьдчилан тааварлахад хэцүү бизнесийн өнөөгийн орчинд гарааны бизнес байгуулах нь амаргүй зорилт байдаг. Залуус өөрийн хүсэл зориг, хичээл зүтгэлээр гарааны бизнес байгуулдаг ч энтрепренёр хүний зайлшгүй мэдэж байх ёстой зүйлсийг мэдээгүйгээс бүтэлгүйтэх тохиолдол түгээмэл байдаг. Тэгвэл Монгол Улсын боловсролын ууган байгууллагуудын нэг МУИС-ийн Бизнесийн сургууль нь бизнесийн удирдлагын сургалтын олон жилийн туршлага, өндөр мэдлэг, чадвартай багш нарын багтаа тулгуурлан энтрепренёр болох хүсэлтэй залууст онол, практикийн нэн чухал суурь олгох «БИЗНЕСИЙН ГАРАА» сургалтыг танд санал болгож байна.

#### СУРГАЛТЫН ЗОРИЛГО

Энэхүү сургалтын зорилго нь залууст бизнесийн шинэ санаа, санаачлагаа бодит амьдралд хэрэгжүүлэхэд зайлшгүй шаардлагатай энтрепренёрын сэтгэлгээ, үр чадвар олгох, бизнесийн онолын мэдлэгийг дээшлүүлэх замаар гарааны бизнесийг амжилттай байгуулж, өргөжүүлэхэд хувь нэмэрээ оруулахад оршино.

#### СУРГАЛТАНД ХЭН ХАМРАГДАХ ВЭ

Бизнес эхлүүлэхээр зэхэж байгаа болон бизнесээ хөгжүүлэх зорилготой хүмүүс, цаашид мэргэших хүсэлтэй төгсөх курсын оюутнууд, төгсөгчид, аж ахуй эрхлэгчид

#### СУРАЛЦАГСДЫН СУРЧ МЭДЭХ ЗҮЙЛС

Энэхүү сургалтаар суралцагч нь:

- Энтрепренёр гэж хэн болох, энтрепренёрын хувьд өөрийгөө хэн бэ гэдгээ ойлгож мэднэ
- Бизнес эрхлэх хүсэл тэмүүлэл, зорилгоо бодитой болгох арга замыг харж, өөртөө итгэлтэй болно
- Энтрепренёр хүнд байх ёстой цагаа төлөвлөх, үр дүнтэй харилцах, баг дахь зөрөлдөөнийг зохицуулах чадварт суралцана
- Амжилттай бизнес болох бизнес санаа олох, түүнийгээ үнэлэх арга техник эзэмшинэ
- Бизнесийн боломжийг илрүүлэх, бизнес санааныхаа зах зээл, салбар, өрсөлдөөнийг үнэлэх арга барилд суралцана
- Бизнес санаагаа амжилтанд хүргэх загварыг зохиох чадвартай болно
- Өрсөлдөөний орчинд давуу тал олох мэдлэг, өрсөлдөөний стратегийн мэдлэгтэй болно
- Гарааны бизнесийн багаа оновчтой бүрдүүлэх мэдлэг, ойлголт авна
- Бүтээгдэхүүний үнэ цэнэ бүрдүүлэх, концепци боловсруулах, маркетингийн хольц, тэдгээртэй уялдуулсан маркетингийн стратегийн мэдлэг эзэмшинэ
- Гарааны бизнесийн санхүүгийн эх үүсвэр олох арга замууд, санхүүгийн бүртгэл хөтлөх, эрсдэлүүдээс сэргийлэх, татварын байгууллагатай харилцах мэдлэг эзэмшинэ
- Компани байгуулах, харилцагчидтай гэрээ байгуулах, хүн хөлсөлж ажиллуулах хөдөлмөрийн гэрээ байгуулах, татварын хууль эрхзүйн мэдлэг эзэмшинэ
- Бизнес төлөвлөгөө боловсруулах, түүнийгээ хөрөнгө оруулагчидад үр нөлөөтэй танилцуулах, илтгэх үр чадварт суралцана

#### СУРГАЛТЫН ҮР ДҮН

Энэхүү сургалтанд хамрагдсанаар суралцагч нь:

- Энтрепренёр болоход сэтгэлзүйн хувьд бүрэн бэлтгэгдсэн байна
- Бизнес санаагаа ажил хэрэг болгох арга замуудыг нэг бүрчлэн мэдэж авсан байна
- Бизнес төлөвлөгөө боловсруулах, түүнийгээ хөрөнгө оруулагчдад танилцуулах үр чадвартай болсон байна
- Нэр хүндтэй энтрепренёруудтай танилцаж, тэдний амжилтын туршлага, бүтэлгүйтлийн шалтгааныг мэдэж авсан байна



# МУИС-ИЙН БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ

## “БИЗНЕСИЙН ГАРАА” ЭНТРЕПРЕНЁРУУДАД

### ЗОРИУЛСАН БОГИНО ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР

#### СУРГАЛТЫН ҮНДСЭН МОДУЛИУД

Сургалт нь дараах үндсэн 7 модуль, тэдгээрийн хүрээнд заагдах хичээлүүдээс бүрдэнэ. Өдөр бүрийн хичээл нэр хүндтэй, туршлагатай энтрепренёрын илтгэл, онолын сургалт, менторинг буюу зөвлөхтэй уулзах цаг, холбоо сүлбээ тогтоох үйл явдлаас бүрдэнэ.

#### Энтрепренёр гэж хэн бэ

- Энтрепренёрын сэтгэлзүй ба бүтээлч зан төлөв
- Энтрепренёрын хувийн үр чадварууд

#### Бүтээлч сэтгэлгээ ба бизнес санаа

- Бүтээлч сэтгэлгээ
- Шинэ санаа бий болгох арга техникүүд
- Шинэ санааг үнэлэх арга техникүүд

#### Гарааны бизнесийн стратеги

- Бизнесийн загвар боловсруулах нь
- Өрсөлдөөний стратеги
- Гарааны бизнесийн багийг оновчтой бүрдүүлэх нь

#### Гарааны бизнесийн маркетинг

- Бизнесийн боломжийг илрүүлэх нь
- Зах зээл, салбар, өрсөлдөгчийн судалгаа
- Маркетингийн стратеги

#### Гарааны бизнесийн санхүүжилт

- Гарааны бизнесийн санхүүгийн эх үүсвэрүүд
- Гарааны бизнесийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндсүүд
- Санхүүгийн эрсдэлүүд, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга замууд (Татвар)

#### Бизнесийн хууль эрхзүйн үндэс

- Иргэний эрхзүй (Гэрээний эрхзүй)
- Компанийн эрхзүй
- Хөдөлмөрийн гэрээний эрхзүй

#### Бизнес төлөвлөгөө

- Бизнес төлөвлөгөө боловсруулах аргагүй
- Бизнес төлөвлөгөөгөө үр нөлөөтэй танилцуулах нь

#### ЗОЧИН ЭНТРЕПРЕНЁРУУД

- Д. Энхбат, “Датаком” ХХК-г үүсгэн байгуулагч, энтрепренёр
- Ш. Алтанбагана, “Терра Экспресс” ХХК-ийн захирал, энтрепренёр
- Х. Ганхуяг, “Хера Холдинг” компанийн ҮЗ-ийн дарга, энтрепренёр
- А. Мэнд-Орших, “Нью Медиа Групп”-ын үүсгэн байгуулагч ба ерөнхийлөгч, энтрепренёр
- В. Баярсайхан, Олуулаа Хөгжил ТББ-ын үүсгэн байгуулагч, энтрепренёр
- Ш. Сүхбаатар, “Монгол Өмгөөлөгч” ХХК-ийн үүсгэн байгуулагч ба захирал, энтрепренёр
- Б. Идэр-Од, CallPro ХХК-ийн үүсгэн байгуулагч ба захирал, энтрепренёр

#### СУРГАГЧ БАГШ НАРЫН БҮРЭЛДЭХҮҮН

- Доктор, профессор М. Должин, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Дэд захирал
- Доктор, профессор Ч. Энхбаяр
- Доктор, дэд профессор Я. Отгонсүрэн, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Маркетингийн хөтөлбөрийн удирдагч
- Доктор, дэд профессор Ц. Түвшинтөр, МУИС-ийн Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургуулийн багш, МТУП-ийн зөвлөх
- Доктор Н. Батдэлгэр, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Менежментийн хөтөлбөрийн удирдагч
- Докторант Г. Үүрдмандах, МУИС-ийн Бизнесийн сургуулийн Бизнес Консалтинг Төвийн менежер
- Бусад

#### СУРГАЛТЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ХУВААРЬ

Үйл ажиллагаа	Өдөр 1 Энтрепренёр гэж хэн бэ	Өдөр 2 Бүтээлч сэтгэлгээ ба бизнес санаа	Өдөр 3 Гарааны бизнесийн стратеги	Өдөр 4 Гарааны бизнесийн маркетинг	Өдөр 5 Гарааны бизнесийн санхүүжилт	Өдөр 6 Бизнесийн хууль эрхзүйн үндэс	Өдөр 7 Бизнес төлөвлөгөө
<b>Бэлтгэл ажил 08.30-09.00</b>							
Өглөөний лекц 09.00-10.00	“Энтрепренёр гэж хэн бэ?”	“Бизнес санаагаа хэрхэн олох вэ?”	“Энтрепренёрт стратеги хэрэгтэй юу?”	“Гарааны бизнесийн маркетинг амжилттай хийх боломж, туршлага”	“Гарааны санхүүжилт босгосон арга туршлага”	“Хууль, эрхзүй, зохицуулалтын орчинд хэрхэн ажиллах вэ?”	“Бизнесийн төлөвлөгөөгөө бусдад хэрхэн ойлгуулах вэ?”
Сургалт 10.00-11.30, 11.30-13.00	- Энтрепренёрын сэтгэлзүй ба бүтээлч зан төлөв	- Бүтээлч сэтгэлгээ - Шинэ санаа бий болгох арга техникүүд	- Бизнесийн загвар боловсруулах нь - Өрсөлдөөний стратеги	- Гарааны бизнесийн маркетинг-I	- Гарааны бизнесийн санхүү – I	- Иргэний эрхзүй (Гэрээний эрхзүй) - Компанийн эрхзүй	- Бизнес төлөвлөгөө боловсруулах аргагүй
<b>Үдийн цаг 13.00-14.00</b>							
Сургалт 14.00-15.30	- Энтрепренёрын хувийн үр чадварууд	- Шинэ санааг үнэлэх аргагүй	- Гарааны бизнесийн багийг оновчтой бүрдүүлэх нь	- Гарааны бизнесийн маркетинг-II	- Гарааны бизнесийн санхүү-II	- Хөдөлмөрийн гэрээний эрхзүй - Татварын эрхзүй	- Бизнесийн төлөвлөгөөгөө үр нөлөөтэй танилцуулах нь
<b>Ментортэй хийх уулзалт 15.30-16.30</b>							
<b>Холбоо сүлбээ тогтоох үйл явдал 16.30-17.00</b>							